

## БЭЛГЭ ДЭМБЭРЛИЙН ҮГ

С. Дулам, Г. Нандинбилиг\*

Монгол аман зохиолын төрөл зүйлүүд зан аалийн болон бэлгэдэлт шинжтэй байдгийг тодорхойёо харуулах нэгэн зүйл нь бэлгэ дэмбэрлийн үгс юм. Юуны өмнө монгол хэлний үгсийн санд нэгэн ижил дуудлагатай ондоон ондоон утгатай гурван ижил нэр (омоним) байдгийн нэг нь хүнээс хүнд дотнолон өгч дурасхадаг “бэлэг” (beleg), оюун ухаан, авьяас эрдмийг тэмдэглэх түрэг гаралтай “билиг” (bilig),<sup>1</sup> “хэргийн урьд урьдаас сэрэгдэх сайн муу ёрыг”<sup>2</sup> хэлдэг “бэлгэ” (belge) гэдгийн чухам аль нь вэ гэвэл сүүлийнх нь буюу сайн муу ёрын “бэлгэ” болно. Монгол хүний хэлдэг уламжлалт бэлгэ дэмбэрлийн үгс нь “амны бэлгээс ашдын бэлгэ” (хувилбар: амны бэлгээр ашдын жаргал ирэх), “амны алдуурснаас ашдын бэлгэ хазайх” хэмээн үздэг бэлгэдлийн сэтгэлгээнээс нь үүдэлтэй аман зохиолын онцлог зүйл болно. Энэ бол монгол хүний оюун сэтгэлгээний салгаж болшгүй өвөрмөц онцлог, монгол утга соёлыг бусад соёлоос ялгаруулах шинж гэдгийг дараах цэцэн үг гэрчилж байна.

*Монгол хүн амны бэлгээр*

*Хятад хүн бэнчингээр*

*Төвд хүн шидээр*

хэмээн хэлэлцдэг нь Ази дахины гурван их соёлт үндэстний оюун сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, монгол хүн бол аливаа зүйлийг хийхдээ, алимад үгийг хэлэхдээ, ер хөдлөж аяглах тоолондоо бэлгэ, бэлгэдлийг урьдаас бодолцож үйлдэж хөдөлдөг, үг хэлдэг зан датхалтай явж иржээ.

Бэлгэ дэмбэрлийн үгс нь эртний хүний нийлэг сэтгэлгээтэй холбоотой анх үүссэн хийгээд үгийн хүч нөлөөг ажил, амьдрал, үйл ажиллагаандаа тус нэмэр болгох гэсэн эрмэлзэл, үгийн ид шидэнд итгэх үзэл эндээс тод харагдана. Хэлбэр зохиомжийн хувьд гол төлөв нэг, хоёр, гурав, дөрвөн...мөрт бадаг шүлгийн бүтэцтэй тул “ерөөлийн богино хэлбэр”[Ч.Содном 1968, 63]<sup>3</sup> гэж үзэх нь ч буй. Зарим монгол угсаатан, тухайлбал, буриадууд бэлгэ дэмбэрлийн үгс гэж тусгай төрөл зүйлийн ялгаагүй бүх ерөөлийг хамтатгаад “үрээл”, “юрөөл” гэхчлэн нэрлэх бөгөөд найман зуу гаруй

\* МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхим

<sup>1)</sup> О.Сүхбаатар, *Монгол хэлний харь үгийн толь*, Улаанбаатар, 1999, 45а (О.Сүхбаатар, 1999)

<sup>2)</sup> *qorin nigetъ tayilburi toil*, 1979, 243 (qorin nigetъ, 1979)

<sup>3)</sup> Ч.Содном, *Бэлгэ дэмбэрлийн үгсээс*, *SF.*, Tom. VI, Fasc. 6, 1968, 63-р тал (Ч.Содном, 1968)

“үрээл” эмхтгэсэн түүврээс<sup>4</sup> үзэхэд ихэнх нь манай бэлгэ дэмбэрлийн үгстэй адил товч богино зүйл байна. Харин “үрээл”, “юрөөл” хоёроо дотор нь ялгахыг оролдож, хоёр ондоо утгатай, хэллэг-авиагаараа адилаархуу үгнүүд юм. Буриад утга зохиолын хэлний үндэс болсон хорь буриадуудын хэлэнд хүмүүст сайн сайхныг хүсч хэлэх үгийг “үрээл” гэж, харин “юрөөл” гэдэг үгээр дацан хийдэд очиж уншуулдаг шашин мөргөлийн номыг хэлдэг аж [Үрээл тогтохо болтогой, 1990, 5]. Тэгвэл халх, дөрвөд, баяд, өөлд, үзэмчин зэрэг бусад ястанд бэлгэ дэмбэрлийн үгс, жинхэнэ ерөөл хоёрын аль аль нь их тархжээ.<sup>5</sup>

Бидний хувьд ерөөл болон бэлгэ дэмбэрлийн үгс бол ирээдүйн сайн сайхныг зөгнөн бэлгэдсэн адил утга, агуулгатай боловч хэлбэр хэмжээ, үүрэг зориулалтын хувьд ондоон ондоон зүйлс гэж үзүүштэй. **Нэгд**, ерөөлийг өдөр тутам хаа сайгүй хэлдэг биш томоохон чухал хүндэтгэлт баяр хурим, зан үйл, ёслолын үед хэлдэг бол бэлгэ дэмбэрлийн үгсийг хаа сайгүй өдөр тутмын ажил, амьдралын дунд хэлж болдог. Тиймээс ерөөл нь зан үйлийн шинжтэй бол бэлгэ дэмбэрлийн үгс нь зан аалийн шинжтэй гэсэн үг. **Хоёрт**, ерөөлийг тусгай мэргэшсэн дэг ёстой, аялга дуудлагатай ерөөлч хүн хэн нэгний дуртган хүссэнээр хадаг, мөнгөн аягатай сүү, хултай айраг мэтийн зан үйлийн эдлэл хэрэглэлтэй хэлдэг бол бэлгэ дэмбэрлийн үгсийг мэргэшлийн бус ерийн хүн болгон тухайн аж амьдрал, ажил үйлийн учир тохиолд нийцүүлэн ерийн байдлаар өөрийн хүсэл зоргоороо өгүүлдэг. **Гуравт**, ерөөл нь эхлэл, өрнөл, төгсгөл болон бусад олон хэсгүүдтэй урт дэлгэрэнгүй аялгуулан хэлэх зүйл байдаг бол бэлгэ дэмбэрлийн үгс нь олон бүтэц хэсэггүй, аль болох товч хураангуй, үл аялгуулан хэлэх зүйл байдаг юм. **Дөрөвт**, ерөөл нь тухайн хэлж буй орчин ахуйдаа нийцүүлэн мэргэшлийн авъяаслаг ерөөлчөөс бэлэн сэцлэж, уртасгаж богиносгож, нэмж хасч, өөрчилж засч болдог тогтмол бус агуулга, бүтэцтэй байдаг бол бэлгэ дэмбэрлийн үгс нэг л ягшмал тогтсон хайрцаг шүлэг юмуу өгүүлбэр бөгөөд түүнийг хэн ч хувирган өөрчилдөггүй тогтмол агуулга, бүтэцтэй. Чухам энэ дөрвөн үндсэн ялгааны улмаас болоод бид бэлгэ дэмбэрлийн үгсийг ерөөлөөс тусад нь зүйл болгон авч үзэж байна.

Ер нь ерөөл, бэлгэ дэмбэрлийн үгсийн гарал үүслийг дом шившлэгтэй холбон үздэг. Бэлгэ дэмбэрлийн үгс нь хэлбэр зохиомжийн хувьд дом шившлэгтэй төстэй боловч үүрэг зориулалтын хувьд тодорхой ялгаатай байна. **Нэгд**, шившлэг ихэвчлэн байгалийн элдэв юм үзэгдэл, далдын хүчинд ханддаг бол бэлгэ дэмбэрлийн үгс нь ямагт хүнээс хүн, мал, амьтанд ханддаг. **Хоёрт**, шившлэгийг тухайн ажил үйлдэл, зан үйлийг гүйцэтгэж буй хүн өөрөө хэлдэг бол бэлгэ дэмбэрлийн үгсийг ажил үйл хийж буй хүнд зориулан өөр бусад хүмүүсээс хэлдэг. **Гуравт**, шившлэг нь ажил үйлс бүтэмжтэй байх, аюул зовлонгоос гэтэлгэх утгаас гадна бусдад хор хөнөөл хүргэх утгатай байж болдог бол бэлгэ дэмбэрлийн үгс хэзээ ч бусдад хор хөнөөл учруулахад бус, харин ямагт сайн сайхныг зөгнөн ерөөх утгатай байдаг. **Дөрөвт**, шившлэгийг мэндчилэх зориулалтаар хэлэх нь огт үгүй бол олонхи бэлгэ дэмбэрлийн үгсийг мэндчилэх зориулалтаар хэлдэг. Эдгээр зааг ялгаа нь энэ төрөл зүйлсийн үүсэл хөгжлийн эхний шатанд төдийлөн ялгараагүй байснаа хожим нэлээд тод ялгарчээ. Энэ нь аман зохиолын төрөл зүйлс

<sup>4</sup>) *Үрээл тогтохо болтогой!* С.Бабуев суглуулуан согсолбо, Улаан-Үдэ, Бурядай номой хэблэл, 1990, 158 с. (Үрээл тогтохо болтогой!, 1990)

<sup>5</sup>) *Х.Сампилдэндэв, Монгол хуримын яруу найргийн төрөл зүйл, Улаанбаатар, 1981, 57 (Сампилдэндэв 1981)*

хөгжлийн эртний шатандаа өөр хоорондоо зааглан салаагүй нийлэг урлагийн шинжтэй оршиж байсныг харуулж буй юм.

Зарим бэлгэ дэмбэрлийн үгс нь бүр эрт балар цагийн ажил үйл, аж ахуйн хэвшлийг тусгасан байх нь үзэгдэнэ. Эрт цагаас өдгөө болтол анчин загасчин отог омгууд явж ирсэн Байгал нуурын дундахь Ойхон олтригийн буриад зоны дунд:

*Шулуу баллаха балтатай байгаарай*

*Шоно үлдэхэ хүлэгтэй байгаарай*

[Үрезл тогтохо болтогой! 1990, 4]

гэсэн бэлгэ дэмбэрлийн үг байдаг нь ан гөрөө хийж, багаж зэмсгээ боловсруулан сайжруулж ирсэн “түүхийг” хүүрнэн буй гэлтэй. Энэ үгийн халх хувилбарт:

*Шувуу гүйцэх хүлгээ унан ир*

*Чулуу цавчих сүхээ аван ир*

[ЗҮАЗ 1987, 81]

гэж өгүүлдэг нь харь овгоос гэрлэх ёс үүссэн тэр үед гэрлэлт бол овог хоорондын хөдөлмөрийн арга туршлага, багаж зэвсгийнхээ шилдгийг солилцох нэгэн зан ёслол болж байсныг илтгэж байна [Сампилдэндэв 1981, 64]. Бэлгэ дэмбэрлийн үгс нь бэлгэдлийн утгатайгаас гадна захиа сургамжийн утгатай ч байна. Хуримлах ёслолын үед хэлэх бэлгэ дэмбэрлийн үгст:

*Хун цагаан хонио туун ир*

*Хусан цагаан уургаа чирэн ир*

[ЗҮАЗ 1987, 81]

гэж гардаг нь бэрд сайн сайхныг хүсэхээс гадна худгуйн талынхны буян хишгийг өөрийн талд дагуулан авчрахыг бэлгэдсэн утгатай юм.

*Чулуутай газар гэрээ барьж*

*Чонотой газар малаа өсгөж яваарай*

[МАЗДБ 1967, 114]

гэсэн үгс нь зовлон бэрхшээлтэй амьдарч яв гэсэн үг бус, харин аливаа саад тотгорыг даван гэтэлж чадахыг [Сампилдэндэв 1981, 65] захисан захиас болно. Энэ мэт зарим бэлгэ дэмбэрлийн үгс нь бэлгэшээн ерөөсөн утгын зэрэгцээ захин сургамжилсан утгатай байна. Зарим бэлгэ дэмбэрлийн үг нь урамшуулах утгатай, дом шившлэгтэй ойр төстэй шившлэг бүхүй байх нь бий. Мянгад ардын хүүхэд хөлд оруулахад хэлдэг үгэнд хүүхэд яг хөлд орох үед нь биенээсээ хөндий зогсоон гараа тосож:

*Хэцүү, хэцүү, хэцүү,*

*Аягачин шанагачин*

*Бөөлөө бөөлөө*

*Алтан мөнгөн*

*Бөөлөө бөөлөө*

*Хэцүү, хэцүү, хэцүү...*

[Лхам 1991, 30]

гэж хэлж урамшуулахад хүүхэд баацаганаан явсаар тоссон гарт хүрч ирнэ. Энэ үгс бас өөрийн гэсэн утгатай бөгөөд хүмүүний аж амьдралын анхны алхам гишгэм бүр нь “хэцүү” гэдгийг сэнхрүүлж, эхлээд аяга шанаганд хурчихвэл цаашаа алт мөнгөнд ч хүрнэ гэсэн бэлгэдэлт санаа агуулжээ. Энэ заншил нь хүүхдийг амархан хөлд оруулах дасгалын маягтай уламжлалт арга ажээ.

Бэлгэ дэмбэрлийн аман зохиолыг утга, сэдвийн хувьд

1.Зан үйлийн холбогдолтой бэлгэ дэмбэрлийн үгс

2.Мал амьтны тухайт бэлгэ дэмбэрлийн үгс

3.Ажил үйлийг ерөөх бэлгэ дэмбэрлийн үгс

гэж үндсэнд нь гурав ялгаж болно.

Үүнээс зан үйлийн холбогдолтой бэлгэ дэмбэрлийн үгсийг авч үзвэл, монгол үндэстний дөрвөн цагийн хурим, баяр ёслол хийгээд тусгай зан үйл, заншил ёсны үед хэлдэг тогтсон үг хэллэг бүхий бэлгэ дэмбэрлийн үгс дийлэнх хувийг эзэлж байна. Жил цагаан сарын битүүлэг, цагаалга, золголт, хүүхдийн угаалга, даахь сэвлэг үргээх, шинэ дээл хувцас анх өмсөх, ураг хурим хийх, алс аянд мордох зэрэгт тус бүрд нь хэлдэг бэлэн зэлэн бэлгэт үгс буй билээ. Бэлгэ дэмбэрлийн үгс нь тухайлсан зан үйл, заншил ёстой нягт холбоотой байхаас гадна мөн ерөөлт мэндчилгээний шинжтэй байдаг. Цагаан сарын шинийн нэгний мэндчилгээнд:

*Хуучин жил хангирч  
Шинэ жил шилжирч  
Хөгшид хүүхэд хөрстэй  
Төлөг сүүлтэй  
Даага далантай  
Бяруу булчинтай  
(Тором бөхтэй)  
Борлон хэрсэнтэй)  
Өн тарган, өг цатгалан  
Сайхан шинэлж байна уу  
[ЗҮАЗ 1987. 79]*

гэхчлэн хэлэлцэж, хөөрөг солилцдог нь шинэ хуучин хоёр он солигдон буй энэ чухаг цаг мөчид хүн зон хотлын амар амгаланг “хөгшид”, “хүүхэд” хэмээх бие тэнхлээр хэврэг насны хоёр туйлаар төлөөлүүлэн асуусан бол мал сүргийн бүрэн бүтэн эсэхийг онд мэнд орсон хоёр настай төл малаар төлөөлүүлэн сурагласан маягтай байна. Сайтар ажиглавал мал малын тарга хүчийг илтгэдэг, барьж тэмтэрч шинждэг эд эрхтнүүдийг төлөөлүүлэн дурдсан нь нэн сонирхолтой бөгөөд энэ бүхэн нийлэхээрээ угсраа төлөөллийн сайхан жишээ болсон байна. Тухайлбал, адууг даагаар, үхрийг бяруугаар, хонийг төлгөөр, тэмээг тормоор, ямааг борлонгоор гэхчлэн дан хоёр настнаар нь төлөөлүүлсэн бол тэдгээр хоёр настнаа тарга хүчийг илтгэгч эрхтнээр нь (дааганы далан, бярууны булчин, төлөгний сүүл, торомны бөх, борлонгийн хэрсэн г.м.) төлөөлүүлжээ гэсэн үг.

Буриад зоны жил цагаан сарын ерөөлт мэндчилгээ нь:

*Жэл бүри жэсгдэ амгалан  
Он бүри омог дорюун  
Сагаалжа, ногоолжо байя даа!  
Хүйтэн үбэлые дабаха солотой,  
Хүхэ нажарые амадаха<sup>6</sup> үрээлтэй,  
Сагаалган – манай найндэр,  
Саг үедэ мандаха болтогой!  
Эгээл найхан хүсэлөө үрээлсэжэ.*

<sup>6)</sup> Зуныг угтая гэсэн үг.

*Муугаа даража, баяраа үргээл.  
Энэ үдэр амар мэндээ мэдэлсэжэ,  
Мүнхэдөө аха дүүнэр болоёл!*

[Үрезл тогтохо болтогой! 1990, 56-57]

гэхчлэн хэлэлцдэг бөгөөд “насан дээрээ нас нэмж байгаа” утгыг “цагаалж, ногоолж” хэмээн илэрхийлсэн нь “...өвсний нэгэн удаа ногоорсныг нэгэн нас болгодог, бусдаас насыг нь асуувал “би хэдүй чинээ удаа ногооруулав гэдэг” [Boγda bayatur 1985, 103-104] эртний монгол заншлаар хэлж буйгаараа сонин байна. Бусад монгол угсаатан, тухайлбал, сөнөдүүд үүнийг “цагаан, ногоон сар” гэхчлэн хоршин хэлэлцдэг нь мөн үүнтэй холбоотой. Ураг хуримын заншил ёсонд хадам эцэг нь хүргэндээ нум сум өгч :

*Өргөн цагаан өрх өсгөж  
Арван цагаан сум сунгаж яваарай*

гэх буюу

*Өрх өсгөж, сум сунгаж яваарай*  
[ЗҮАЗ 1987, 77]

гэж ерөөдөг нь үр удам тасрахгүй, өнөр баян болог гэж бэлгэдэж буй хэрэг юм. Монгол домог зүй-бэлгэдэл зүйд өрхийг *гэрийн сүлд*, *гэрийн нагац* хэмээн эрхэмлэн хүндлэх бөгөөд “өрх өсгөнө” гэдэг бол нэг айл олон болно гэсэн үг. Харин сум бол нэг хүнийг, тэр тусмаа эр хүнийг төлөөлдөг, “эр хүмүүн дор хийморь заль болсон эрдэнийн оюун цагаан сум” [Дулам 1989, 27-29]<sup>7</sup> гэж нэрлэдэг билээ. Тэхлээр “сум сунгана” гэдэг маань нэг хүн олон хүн болно гэсэн санаа мөн. Монгол бэлгэ дэмбэрлийн үсгийн дотор үрийн хутаг ба насан хутгийг ерөөсөн бэлгэ дэмбэрлийн үг багагүй хувийг эзэлдэг. Хурим найрын үеэр ахмадууд үр зөөртөй болохыг зөгнөн:

*Хандгай буга харвах хүүтэй бол  
Халиу булга эсгэх хүүхэнтэй бол*  
[ЗҮАЗ 1987, 78]

гэж ерөөдөг нь ангуучин гөрөөчин үеийн аж амьдралын тусгал мөн бол, мөн шинээр гэр бүл болж байгаа залууст ахмадууд унага даага зүслэн өгөхдөө:::

*Үрээ танихгүй өнөр  
Үрээгээ танихгүй баян болтугай*  
[ЗҮАЗ 1987, 82]

*Даага чинь дал хүр  
Нас чинь ная хүр*

[ЗҮАЗ 1987, 79]

гэх зэрэг бэлгэтэй үгсийг хэлдэг нь мал ахуй эрхлэх болсон цаг үеийн тусгал болно. Энэхүү бэлгэтэй үгэнд хариу хэлэх бэлгэ дэмбэрлийн үгс гэж бас буй. Үүнд:

*Буурлын буян  
Бум хүрэх болтугай  
Та улам урт насалж  
Удаан жаргаарай*

гэх буюу:

*Дал хүртлээ  
Дал хувааж идье*

[ЗҮАЗ 1987, 81]

<sup>7</sup> Дулам С, Монгол домог зүйн дүр, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1989, 192 т.

*Зуу насалж  
Зургаадай<sup>8</sup> таяг тулж яваарай*  
[ЗҮАЗ, 1987, 82]

гэхчлэн урт наслахын насан хутгийг ерөөсөн үгийг хэлэлцдэг.

**Мал амьтны тухайт бэлгэ дэмбэрлийн үгсийн** нэлээд хувь нь **адуу малтай холбогдох** ба хурдан морь уях зан үйлтэй эн тэргүүнд холбогдож байна. Унага уяхад:

*Ногтолсон унага  
Ногтруунаас олон болог  
Ногтондоо номхорч  
Чагтандаа дасах болтугай*  
[ЗҮАЗ 1987, 84]

гэж хэлдэг бол морь уяж сойх буюу уралдаж байх үед

*Хулэг нь хурдан  
Хүүхэд нь хөнгөн болог  
Муу хөлс нь гарч дуусаг  
Шар үс нь унаж дуусаг  
Үсэргээ нь зохиж  
Амьсгаа нь задраг*

[ЗҮАЗ 1987, 83]

гэхчлэн мөр зохистой, өлзий бэлгэтэй сайхан үгсийг хэлэлцдэг.

**Мал амьтны тухайт бэлгэ дэмбэрлийн үгс** нь дотроо нэлээд эртний үүсэл гаралтай байж болох амьтантай холбоо бүхүй бэлгэ дэмбэрлийн үгс, арай хожуу үед гарсан байж болох мал сүрэгтэй холбоотой бэлгэ дэмбэрлийн үгс гэж байна.

Ан гөрөөний олз омог ерөөхдөө:

*Хада гэххэхэ гэжэ  
Халюу гэххэхэ яба  
Бута гэххэхэ гэжэ  
Булга гэххэхэ яба<sup>9</sup>*

гэсэн нь хөлийн дороос нь босох мэт элбэг дэлбэг тохиолдох үслэг ангийн нарийныг олз болгон агнаж явахыг зөгнөсөн бол

*Олон зондо солотой ябажа  
Омоли загаһанай тарганые баригты  
Ута онгосын хотойтор  
Ута губиуурай нахиитар  
Олзын ехэдэ хүртэгты!*

[Үрээл тогтохо болтогой 1990, 81]

гэхчлэн Байгал далайн алдарт омуль загасыг онгоцоо хотойтол, гувчуураа нахийтал элбэг арвин загасчлахыг ерөөж байна.

Монголчуудын дунд загас гөгдсөн хүнд:

*Бар бар бар  
Бардам эрийн олз*

<sup>8)</sup> Зургаан талтай, шаравтар өнгийн, хатуу, хүнд мод, эрх хийвэл үл сэтрэх бөгөөд улам хатуу мөлгөр болно. Хятадын Утай шан ууланд голдуу ургадаг.

<sup>9)</sup> С.С.Бардаханова, Малыё жанры бурятского фольклора, Улан-Удэ, Бур.кн. изд-во, 1982, 150 (Бардаханова, 1982)

*Бар бар бар  
Баян хангайн хишиг тогтог*

гэхчлэн олз хишгийн ерөөл талбих нь ч буй.

Бэлгэ дэмбэрлийн үгс нь ямагт хүндэтгэлийн аястай байдаг. **Ажил үйлийг ерөөх** бэлгэ дэмбэрлийн үгс нь олонхидоо байнга давтагдан тогтвортой хэрэглэгддэг бөгөөд тухайн ажил үйлтэйгээ утга агуулгаараа нягт холбоотой байна. Тогоо нэрж байгаа айлд орохдоо:

*Архи нь хатуу  
Айраг нь чанга  
Аарц нь өтгөн бол  
Архи нь арз  
Авгай нь дагина бол*

гэдэг бол айраг бүлж байвал,

*Тос их унах болтугай*  
[ЗҮАЗ 1987, 82]

гэж, цай буцалж байхад айлд орвол:

*Буцалсан цай чинь бурам болж  
Буусан айл минь баян бол*  
[ЗҮАЗ 1987, 82]

хэмээн тухайн буусан айл өрхийн болон халуун ам бүлийн, идээ ундааны сайн сайхныг зөгнөн ерөөсөн үгсийг хэлдэг. Түүнчлэн,

үйл ур үйлдэж байвал – “*Үйл уран болтугай*”  
бичиг бичиж байвал – “*Бийр хурц болтугай*”  
байшин барьж байвал – “*Мэс хурц болтугай*”  
гэр барьж байвал – “*Гэр хэвтэй сайхан болтугай*”  
хонь хяргаж байвал:

*Хайч хурц болтугай...  
Хайч чинь хурц бол  
Ахар чинь арвин бол...  
Хайч хурц  
Хайчилсан хонь  
Мянга түм хүрэг ээ...*

[ЗҮАЗ 1987, 78-79]

Эсгий хийж байхад:

*Төрийн эд төвтэй сайн болтугай  
Төрсөн бие мөнх болтугай  
Хурганы ноос хуруу зузаан  
Төлөгний ноос төв зузаан  
Далан гэрийн бүрээс бол  
Далай ламын жавдан бол...  
Цаснаас цагаан  
Яснаас хатуу  
Дун шиг артай  
Дурдан шиг энтэй болтугай*

[ЗҮАЗ, 1987,19]

гэхчлэн эдэд нь хандсан юмуу, эзэнд нь хандсан, хүмүүний сэтгэл ухааныг уужлах, ашдын аз жаргалан сайн сайхныг болон үйлс бүтэмжийг ерөөсөн өлзий бэлгэтэй үгсийг хэлдэг байна.

Монголчууд эртнээс нааш эсгийг “төрийн эд” хэмээн хүндэлж, цагаан толог эсгийг дээр эзэн хаанаа залж ирсэн бөгөөд эсгийгээр ширдэг ширээд дуусахдаа,

*Дэлхийн зовлонг үүрч байхаар*

*Дээвэр болох нь ч яав даа*

гэж ширдэгний эсгий ёолдог юм гэнэ лээ, шинэ гэрийн хоймор дэвсэх гэж байна”<sup>10</sup> гэж шившлэгийн шинжтэй үгс хэлэлцдэг уламжлал ч байжээ. Энэ нь аливаа хатуу хүтүү, зовлонтой бэрхийг үгийн сайн сайхан бэлгээр зөөллөх гэсэн санаа байна.

Бэлгэ дэмбэрлийн үгийн хариуд ахмад болон жирийн хүнд “*тэр бэлгэ сайхан оришугай*”, “*ерөөл өлзий болтугай*”, “*ам өлзийтэй болог*”, “*бэлгэ бүттүгэй*”, “*ерөөлөөр болтугай*”, “*ерөөл тогтог*” гэж хэлдэг бол үе тэнгийн хүнд “*мор зохитугай, мөндөл шиг олон хүүхэдтэй болтугай*” [Содном 1968, 66] гэх мэтээр наргиан хөгжөөнтэй хариу өчдөг байна.

Энэ бүхнийг дүгнэн цэгцэлж үзвэл, монгол аман яруу найргийн нэгэн өвөрмөц зүйл болох бэлгэ дэмбэрлийн үг нь:

1. “Амны бэлгээс ашдын бэлгэ” хэмээх монгол бэлгэдлийн гүн ухааны өдөр тутмын аж хэрэглээний тусгал, салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж, ямагт ирээдүйн сайн сайхныг зөгнөсөн тарни шившлэгийн шинжийг хадгалж байдаг.
2. Зан аалийн шинжийн хувьдаа бэлгэ дэмбэрлийн үгс нь ерөөлт мэндчилгээний зүйл болж уул ажил үйлсийнхээ зан аалийн онцлогийг тодотгож байдаг.
3. Шүлгийн хэлбэр, бүтцийн хувьд нэн тогтмол бөгөөд аль болох товч хураангуй, хэлэхэд ур дүйтэй хэвшмэл хэлц болсон байдаг.

### ЗҮҮЛТИЙН НОМ ЗҮЙ

1. Бардаханова С.С (1982), *Малые жанры бурятского фольклора*. Улан-Удэ: Бур. кн. изд-во.
2. Гаадамба Ш, Цэрэнсодном Д (1978), *Монгол ардын аман зохиолын дээж бичиг* (Нэмэн засварласан хоёр дахь хэвлэл), Редактор Ц.Дамдинсүрэн, Улаанбаатар, УХГ.
3. Гаадамба Ш, Сампилдэндэв Х (1988), *Монгол ардын аман зохиол*. Улаанбаатар.
4. Дулам С (1989), *Монгол домог зүйн дүр*, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 192т.
5. Лхам Д (1991), *Мянгад ардын зан үйл, аман зохиол*. Улаанбаатар.
6. ЗҮАЗ (1987), *Монгол ардын зан үйлийн аман зохиол*. “Монгол ардын аман зохиолын чуулган” цуврал, VI боть, Эмхтгэж, удиртгал, тайлбар бичсэн Х.Сампилдэндэв, Улаанбаатар.

<sup>10)</sup> 1998 онд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын иргэн, 80 настай эмгэн, Лханаагийн Сосороос тэмдэглэн авав.

7. Сүхбаатар О (1999), *Монгол хэлний харь үгийн толь*, Улаанбаатар, 45а
8. Сампилдэндэв Х (1981), *Монгол хуримын яруу найргийн төрөл зүйл*, Улаанбаатар.
9. Содном Ч (1968), *Бэлгэ дэмбэрлийн үгсээс*, SF., Tom.VI, Fasc.6.
10. Хорлоо П (1969), *Монгол ардын ерөөл*, Улаанбаатар.
11. *Үрээл тогтохо болтогой!* (1990), С.Бабуев суглуулан согсолбо. Улаан-Үдэ: Бурядай номой хэблэл.
12. [MAAJE] (1946), *Mal aju aqui-yin tuqai arad-un aman jokiyal-un emkidkel*, Red. Sodnam, Ulayanbayatur.

### SUMMARY

Auspicious words of greeting (*belge demberliin ug*) are a clear example of the customary and symbolic qualities of Mongolian oral literature.

The significance of Mongolian auspicious words of greeting can be summarized as follows:

1. They reflect and constitute an essential element of Mongolians' everyday symbolic philosophy, summarized by the saying "eternal auspice from oral auspice", preserving the qualities of mantras wishing for continuous future good fortune.
2. From the perspective of their customary role, these auspicious words serve as benedictive greetings that highlight the customary aspects of the activities to which they relate.
3. From the perspective of their poetic form and structure, they are extremely fixed and concise, taking the form of popular, artistic sayings.